



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 11 сарын 12 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “улсын байцаагч” гэсний дараа “, гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагч” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “гаалийн” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР